



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 5/130

Хэрлэн сум

**Г.Сайханбаярыг туршилтын
хугацаагаар ажилд томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолоочоор Гомбосүрэнгийн Сайханбаярыг 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс туршилтын 3 сарын хугацаагаар томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:
Комиссын

дарга: Л.Дугар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Э.Ариунтунгалаг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав

3.Г.Сайханбаярын сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 827,000 (найман зуун хорин долоон мянга) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Г.Сайханбаярт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА

